



Хичээл бүртгүүлэх гарын авлага

1. SISI мэдээллийн системийн товч танилцуулга

“SISI 3.0” системийн үндсэн хэсэг нь интернетийн сүлжээнд холбогдсон компьютерээс хандаж ажиллахаар хийгдсэн сургалтын дотоод үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилготой бүртгэл, мэдээллийн систем юм.

Багш, оюутан, сургалтын албаны ажилтан, удирдах ажилтнууд системд хандан ажиллах бөгөөд оюутан таныг манай сургуульд анх элсэн орохоос эхлээд төгсөх хүртэлх бүхий л хугацааны туршид ашиглагдах болно. Системийг англи, монгол хэл дээр ашиглах боломжтой.


Оюутан үзэж судалсан хичээлүүдийнхээ үнэлгээ болон, голч оноо, голч дүнгийн мэдээлэл, суралцаж байгаа сургалтын төлөвлөгөө, МУИС-ийн хэмжээнд заагдаж байгаа хичээлүүдийн агуулга, зорилготой танилцах, сонирхсон хичээлдээ бүртгүүлэх, багшаа сонгох, судалсан хичээлийнхээ агуулга, багшийн заах арга барил, сургалтын орчны талаар санал асуулга өгөх болон бүрэлдэхүүн сургууль, тэнхим, хичээлтэй холбоотой асуудлаар санал хүсэлт, асуулт, хариултыг хэлэлцүүлэгт бичих боломжтой юм. Мөн бүрэлдэхүүн сургуулийн болон өөрийн хувийн хичээлийн хуваарийг тухайн өдрөөр, долоо хоногоор харах, төлбөрийн мэдээллийг авах, хэрвээ бүртгэлийн мэдээлэл алдаагүй гэж зөвшөөрсөн тохиолдолд оюутны цахим үнэмлэхээ захиалах боломжтой бөгөөд сургуулиа амжилттай төгсөх үед системээс төгсөлтийн диплом хэвлэгдэн гарах болно.

SISI системд нэвтрэхийн тулд Internet Explorer веб броузерыг нээж <http://sisi.num.edu.mn> хаягаар хандана. (Зураг 1.)



Зураг 1. SISI системд нэвтрэх

Нэвтрэх хуудасны (Зураг 2.) “Хэрэглэгчийн нэр” хэсэгт сургуулиас олгосон оюутны бүртгэлийн дугаарыг (Энэ дугаар оюутны үнэмлэх дээр хэвлэгдэнэ. Жишээ нь: 10B11A20111), “*****” хэсэгт нууц үгээ бичнэ. Анхны нууц үг нь таны төрсөн он, сар, өдөр (жишээ нь: 1990 оны 1-р сарын 1-нд төрсөн хүнийх 19900101) байх бөгөөд та нэвтэрсний дараа нууц үгээ солих боломжтой.



Зураг 2.
SISI системийн
нэвтрэх хуудас



“Доорх кодыг оруулна” талбарт 3 тэмдэгтээс бүтэх зурган кодыг оруулж өгөх ба энэхүү код нь таны хандалт бүрт өөр өөр тэмдэгтүүд байна. Ингэснээр та давхар хамгаалалт хийж байгаа гэсэн үг юм. Хэрэглэгчийн нэр, нууц үг, зурган кодыг оруулаад “Нэвтрэх” товч дээр даран системд нэвтэрнэ.

Хэрвээ та нэвтэрч чадаагүй бол энэ нь дараах шалтгаантай байж болно.

1. Хэрэглэгчийн нэр, нууц үг, зурган кодыг буруу оруулах Хэрэглэгчийн нэр, нууц үг, зурган кодыг англиар бичихийг анхаарна уу.
2. Хэрэглэгчийн эрхийг үүсээгүй байх. Оюутны системд хандах эрхийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны ажилтан үүсгэдэг. Хэрвээ та хэрэглэгчийн нэр, нууц үг, зурган кодыг зөв оруулсан боловч нэвтэрч чадаагүй бол сургуулийнхаа сургалтын албаны ажилтанд хандан эрх үүсгэсэн эсэхийг тодруулаарай.
3. Мэдээлэл алдаатай бүртгэгдэх. Оюутны хандах эрхийн анхны нууц үг нь төрсөн он, сар, өдөр байдаг тул хэрвээ бүртгэлийн мэдээлэлд алдаа гарсан бол та нэвтэрч чадахгүй. Тиймээс сургалтын албаны ажилтанд хандан бүртгэлийн мэдээллээ шалгана уу.

Системд нэвтэрсний дараа системд ажиллах заавартай “Тусламж” хэсгээс дэлгэрэнгүй танилцана уу.

2. Хичээлд бүртгүүлэх

Хичээлд бүртгүүлэх үйл ажиллагаа хоёр үе шаттай, цахим хэлбэрээр явагдана.

- ✓ Оюутан тухайн улирлын 13, 14 дэх долоо хоногт багтаан, дараагийн улиралд заавал судлахаас гадна сонгож судлах хичээлээ сонгон, санал гаргана.
- ✓ Ирэх улиралд орох хичээл, анги танхим, цаг, багшийн талаарх мэдээлэл бүхий хичээлийн ерөнхий хуваарийг салбар сургалтын алба улирлын шалгалтын хугацаанд бэлэн болгоно. Амралтын эхний гурван долоо хоногт оюутан хичээлийн хуваарийг үндэслэн хичээлд бүртгүүлэх ба хэрэв тухайн хичээлийг судлах оюутны тоонд багтахгүй бол хүлээлгийн жагсаалтанд нэрээ бүртгүүлж болно.

2.1. Хичээлд бүртгүүлэлт(Санал)

Хичээлд бүртгүүлэлтийн саналын үе нь тухайн улиралд суралцаж байгаа оюутнууд дараагийн улиралд ямар хичээл үзэх хүсэлтэй байгааг авдаг. Оюутнуудын саналыг үндэслэн тэнхим сургалтын алба дараагийн улиралд ямар хичээлийг аль багш хичнээн заах мөн хичнээн оюутан суралцахыг тодорхойлдог.

Зураг 3.
SISI системийн
үндсэн хуудас



МУИС, ЭЗС-ийн хичээлд бүртгүүлэлт(Санал) 2012/11/14 0:00 - 2012/11/17 0:00 хооронд явагдана.

Хичээлд бүртгүүлэх(Санал өгөх) зааврыг [Энд дарж үзнэ үү](#)

Хичээлд бүртгүүлэхээр санал өгөх нь эцсийн сонголт биш бөгөөд энэ нь хичээлийн хуваарь зохиоход (анги хуваарилалт, багш оноолт гэх мэт) туслах зорилготой юм. Оюутан та хичээл сонголтод идэвхгүй оролцсоноос болж эцсийн хичээл сонголтод багтахгүй байх (жишээ нь: анги дүүрсэн байх) магадлалтай тул идэвхтэй оролцоно уу!

- ★ Судалсан эсвэл судалж байгаа
- ☆ Сонгох боломжтой
- ☆ Судлах боломжгүй

А. Ерөнхий суурь хичээл

A1. Заавал судлах хичээл				
1	☆	COMP100	3 багш	Мэдээллийн технологи, мэдээллийн бааз
2	★	SPRT100	3 багш	Биеийн тамир
3	☆	ENGL102	6 багш	Англи хэл (Анхан дунд түвшин)
4	☆	ENGL103	6 багш	Англи хэл (Дунд түвшин)
5	☆	ENGL104	6 багш	Англи хэл (Ахсан дунд түвшин)

Санал өгөхөөс өмнө анхууралгыг сайтар уншина

Хичээлийн тэмдэглэгээний тайлбар

Багш сонгох

Зураг 4. Санал өгөх хуудас

The screenshot shows a web application interface for course selection. On the left is a navigation menu with items like 'Нүүр хуудас', 'Хичээлийн хуваарь', 'Хичээл сонгох', etc. The main area displays a list of courses under the heading 'A1. Заавал судлах хичээл'. Course 3, ENGL102, is highlighted with a yellow box and a 'цуцлах' (collapse) button. A message dialog box is open over the course list, asking: 'Бизнесийн англи хэл (Анхан дунд түвшин) хичээлийг сонгох уу? Сонгох бол Ок, үгүй бол Cancel дарна уу!' (Do you want to select Business English (Intermediate level) course? Select Ok if yes, Cancel if no). A blue callout box on the left points to the 'Хичээл сонгох' (Select course) icon in the navigation menu.

Зураг 5. Санал өгөх хуудас



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

5)	★	ENGL104	6 багц	Англи хэл (Ахисан дунд түвшин)	
6)	★	ENGL207	2 багц	Бизнесийн англи хэл (Ахсан дунд түвшин)	
7)	★	ENGL208	2 багц	Бизнесийн англи хэл (Дунд түвшин)	
8)	★	ENGL209	2 багц	Бизнесийн англи хэл (Ахсан дунд түвшин)	
9)	★	MAEC101	3 багц	Математик I	
10)	★	MAEC102	3 багц	Математик II	
11)	★	LOGI100	2 багц	Логик	Г.Лодой

A2. Сонгон судлах хүмүүнлэгийн үнэмлэхүй хичээлүүд

1)	★	HIST100	3 багц	Истори	
2)	★	PHIL100	3 багц	Философи	
3)				Сонгосон багш багш сонгоогүй байна	
4)	★	LANG100	2 багц	Монгол хэлний найруулга зүй	
5)	★	RUSH100	3 багц	Орос хэл III	
6)	★	HDEV100	2 багц	Хүний хөгжил	Р.Дарьхүү
7)	★	CULT100	2 багц	Соёл судлалын үндэс	Р.Дарьхүү
8)	★	RUSH100	3 багц	Орос хэл	

Message from webpage
Экологи, байгаль хамгаалал хичээлийг сонголтоосоо хасах уу?
Хасах бол Ok, үгүй бол Cancel дарна уу!

OK Cancel

Сонголтыг цуцлах

Зураг 6. Санал өгөх хуудас

Нэгдүгээр ангийн оюутнуудын хувьд намрын улиралын хичээл бүртгүүлэлт хийхдээ санал өгөх шатыг алгасан шууд хичээлд бүртгүүлэх болно.

2.2. Хичээлд бүртгүүлэлт(Баталгаажуулалт)

Хичээл бүртгүүлэхдээ зарласан хугацаанд багтааж бүртгүүлэх шаардлагатайг анхаарна уу. Хоцорсон тохиолдолд оюутан тухайн улиралд хичээл судлахгүй эсвэл нэмэлт төлбөр төлж хичээлд бүртгүүлэх болно.

Хичээллийн бүртгүүлэлт(Баталгаажуулалт)-ын 2 дахь шат нь дотроо мөн 2 үе шаттай.

- ✓ Хичээл сонголт
- ✓ Баталгаажуулалт


Энэ нь оюутан өөрийн хичээлийн хуваарийг зөв төлөвлөхөд чиглэгдсэн болно. Хичээл сонголтоор оюутан өөрийн үзэх хичээл, заах багш өдөр цагийг сонгох ба цагийг давхцал анги дүүргэлт зэрэгийг хянаж хичээлийн хуваариа боловсруулах болно. Хичээл сонгосноор оюутан тухайн хичээлд бүртгүүлсэн гэсэн үг биш бөгөөд эцсийн байдлаар бүртгүүлхийн тулд тухайн сонгосон хичээлээ баталгаажуулах шаардлагатай.

Зураг 8.-т хичээл бүртгүүлэх хуудасыг харуулсан ба уг хуудсанд судалсан болон судлах боломжтой, боломжгүй хичээлүүдийн жагсаалт байна.



Хичээл бүртгүүлэх хэсэгт нэвтрэх

Зураг 7. SISI системийн үндсэн хуудас



Зураг 8. Хичээл бүртгүүлэх хуудас

Хичээлийн төлөвүүд /зураг 9./


- ✓ Судлах боломжтой буюу ногоон таван хошуугаар тэмдэглэгдсэн хичээл нь тухайн улиралд хуваарь дээр тавигдсан, судлах боломжтой хичээлүүд.
- ✓ Судлах боломжтой боловч хичээлийн хуваарьт тавигдаагүй буюу бүдэг ногоон таван хошуугаар тэмдэглэгдсэн хичээл нь тухайн улиралд хуваарь дээр тавигдаагүй боловч оюутан дараа улиралд анги бүрдэлт үүсвэл судлах боломжтой хичээлүүд.
- ✓ Судалсан эсвэл судлаж байгаа шар таван хошуугаар тэмдэглэгдсэн хичээлийг оюутан судалчихсан эсвэл тухайн улиралд судлахаар аль хэдийн сонгочихсон хичээлүүд.
- ✓ Судлах боломжгүй буюу саарал таван хошуугаар тэмдэглэгдсэн хичээл нь тухайн оюутан уг хичээлийн суурь хичээлийг судлаагүй байгаа хичээлүүд.



- ✓ Судлах боломжгүй хичээл сонгосон ямарваа нэг процедурын алдаанаас /дүн алдаатай орох г.м/ шалтгаалан судлах боломжгүй байсан хичээлийг сонгосон байх. Ийм тохиолдол тухайн хичээлийг цуцлах боломжтой.

- ★ Судлах боломжтой
- ☆ Судлах боломжтой боловч хичээлийн хуваарьт тавигдаагүй
- ★ Судалсан эсвэл судалж байгаа
- ☆ Судлах боломжгүй
- ★ Судлах боломжгүй хичээл сонгосон

Зураг 9. Хичээлийн төлөвүүд



Зураг 10. Хичээлийн мэдээлэл


Оюутан хичээл дээр дарж тухайн хичээлийн дэлгэрэнгүй мэдээллийг харж болно /зураг 10/.

8.	★	POCI101	2.5 бц	Философийн үндэс
9.	☆	PHYS102	2 бц	Цахилгаан соронзон
10.	★	COMP100	3 бц	Мэдээллийн технологи, мэдээллийн бааз
11.	★	EMAT201	3 бц	Магадлалын онол, санамсаргүй процесс
12.	☆	MATH101	4 бц	Инженерийн математик I
13.	★	MATH102	4 бц	Инженерийн математик II

Зураг 11. Хичээл бүртгүүлэх

Хичээл бүртгүүлэхдээ судлах боломжтой хичээлийн өмнөх /ногоон/ таван хошуун дээр дарна уу. /Зураг 11./


Лекц болон лаборатори/семинар-аас өдөр цагийг сонгоно /Зураг 12./



Зураг 12. Хичээл сонгох




Хэрэв танд *Зураг 13*. дээрх цонх харагдаж байвал та өмнөх улиралд явагдсан хичээл бүртгүүлэх санал авах процесст тухайн хичээлд санал өгөөгүй байна гэсэн үг. Өмнөх улиралд тухайн хичээлийг сонгохоор санал өгсөн оюутанд 48 цагийн давуу эрх олгож байгаа учир хэрвээ та санал өгөөгүй бол хичээл бүртгүүлэлт эхэлснээс хойш 48 цагийн дараа уг хичээлийг сонгох боломжтой болно.




Зураг 13. Хичээл сонгох

Хэрэв танд *Зураг 14*. дээрх цонх харагдаж байвал тухайн хичээлийн цаг таны өмнө нь сонгосон аль нэг хичээлийн цагтай давхцаж байна гэсэн үг. Та цагаа шалгаад боломжит өөр цагийг сонгоно уу.




Зураг 14. Хичээл сонгох

Хэрэв та *Зураг 15*. дээрх цонх харагдаж байвал тухайн хичээлийн лекц болон лаборатори/семинарын аль нэг эсвэл бүх танхим дүүрсэн байгаа болно. Та анги дүүргэлтийг шалгаад хичээл бүртгүүлэлтээ хийнэ үү.



Зураг 15. Хичээл сонгох

Хичээл бүртгүүлэлт амжилттай болвол танд Зураг 16. дээрх цонх харагдана.



Зураг 16. Хичээл сонгох

Амжилттай сонгосон хичээлийн хуваарь.

1.	★	TEAC302	3 бц	Физик дидактик II	
2.	★	TEAC312	2 бц	Физик туршилтын арга зүй II	
3.	Цуцлах	Лекц: Дэлгээн Ж (Лхагва 09:00-10:30) Лаборатори: Дэлгээн Ж (Лхагва 10:40-12:10)	TEAC420	3 бц	Сургалтын Е хэрэглэгдэхүүн бэлтгэх
4.	★	PSYC200	2 бц	Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал	


Зураг 17. Хичээл сонгох




2.3. Баталгаажуулалт

Хичээл сонголтыг баталгаажуулсанаар та тухайн хичээлд албан ёсоор бүртгэгдэх ба баталгаажуулахын тулд тухайн улиралд судлах кредитийн төлбөр болон суурь хураамж заавал төлөх болно.

Хичээл баталгаажуулсны дараа хичээлийг цуцлах бол нэмэлт төлбөр төлөх болохыг анхааран **сонголтоо хариуцлагатай хийгээрэй.**



Зураг 18. Сонгосон хичээлийг цуцлах




Зураг 19. Сонгосон хичээлийг баталгаажуулах

Баталгаажуулалт нь банкны системтэй холбогдсон бөгөөд багцын төлбөрийг онлайн хэлбэрээр төлөх болно.

Нийт кредит:	3
Нэг кредитийн төлбөр:	39900
Нийт кредитийн төлбөр:	119700
Суурь хураамж:	0
Нийт төлбөр (шимтгэл орсон):	120700


Сонгосон кредит цаг болон суурь хураамжийг нэхэмжилсэн хуудас банкны систем очих бөгөөд төлбөрөө төлөхөд тухайн банкны гүйлгээний эрхтэй карт хэрэглэнэ.

Төлбөр төлснөөр таны сонгосон хичээлүүд баталгаажих болно.



Зураг 20. Төлвөл зохих төлбөрийн нэхэмжлэл



Information about order / Гүйлгээний тухай мэдээлэл	
Merchant ID (Үйлчилгээний байгууллагын дугаар)	MUIS-MTS
Currency (Валютын төрөл)	Tugrik (MNT)
Amount (Гүйлгээний дvн)	120,700.00
Invoice number (Нэхэмжлэлийн дугаар)	CRI823/71
Card Information /Телберийн картын мэдээлэл	
Card number (Картын дугаар)	123456789****
Cardholder name on card (Картан дээрх нэр)	batbayar
Expiration date (Картны хвчинтэй хугацаа)	4 2014
Card Verification Number (CVV код) <small>Картын ард талд дугаарын ард байгаа 3 оронтой тоо</small>	123
	
Telephone Number (Холбоо барих утасны дугаар)	99*****
E-mail address (Электрон шуудангийн хаяг)	email@yahoo.com
Телбер хийх/Do payment >	
АНХААРУУЛГА	
<p>Та Голомт банкны картаар төлбөрөө төлөх бол картын нууц кодоо тус банкны аль нэг салбараас авсан байх шаардлагатай. Энэ код нь АТМ машинаас мөнгө авахад хэрэглэдэг PIN кодоос ялгаатай гэдгийг анхаарна уу.</p>	

Банкны систем очсон төлбөрийн нэхэмлэл

Картын мэдээлэлд ямар нэг асуудал гарвал тухайн банкандаа хандахыг зөвлөж байна.

Зураг 21. Картын мэдээлэл оруулах хэсэг

Картны мэдээллийг зөв бөглөснөөр банкны системээс таны гүйлгээний **e-code** асуух болно.

Төлбөр төлөх карт нь заавал тухайн оюутны карт байх албагүй бөгөөд онлайн гүйлгээний эрхтэй заасан банкны дотоодын карт байх ёстойг анхаарна уу!!!



Information about order / Гүйлгээний тухай мэдээлэл

Merchant ID (Үйлчилгээний байгууллагын дугаар)	MUIS-MTS
Currency (Валютын төрөл)	Tugrik (MNT)
Amount (Гүйлгээний дvн)	120,700.00
Invoice number (Нэхэмжлэлийн дугаар)	CRI823/71

Are you sure ? / Та итгэлтэй байна уу ?

Amount (Гүйлгээний дvн)	120,700.00
Card number (Картын дугаар)	5587
Cardholder name on card (Картан дээрх нэр)	batbayar
Expiration date (Картны хвчинтэй хугацаа)	0114
Card Verification Number (CVV код)	123
Telephone Number (Холбоо барих утасны дугаар)	99*****
E-mail address (Электрон шуудангийн хаяг)	email@yahoo.com
E-Code/ E-Token	****

E-Code – Банкнаас харилцагч Танд олгох 4 оронтой нууц код. Өөрөөр хэлбэл Интернэтээр картын үлдэгдэл шалгахад ашигладаг код юм. Хэвээ та E-Code-оо мэдэхгүй эсвэл мартсан бол салбарт хандана уу.
E-Token – Хэрэв харилцагч та интернэт банкны эрхтэй, түүндээ E-Token ашигладаг бол уг төхөөрөмжөөс гарах 6 оронтой нууц кодоо ашиглана

Лавлах төв: 1646, callcenter@golombank.com

Буцах/Back Төлбөр хийх/Do payment

Verified by VISA MasterCard SecureCode Secured by Golomt bank of Mongolia 2009 About SSL Certificates

Банкны систем очсон төлбөрийн нэхэмлэл


Банкнаас авсан гүйлгээний e-code-ийг энэ хэсэгт бөглөнө. Хэрэв e-code оруулах талбар гарч ирэхгүй бол та картын мэдээлэл дахин шалгана уу

Зураг 22. E-code оруулах хэсэг

Ерөнхий суурь хичээл				
Заавал судлах хичээл				
1.	★	COMP100	3 бц	Мэдээллийн технологи, мэдээллийн бааз
2.	★	Семинар:Баньдхүү Ж (Мягмар 13:00-14:30)	SPRT100	3 бц Биеийн тамир
3.	★	FNDP100	1 бц	Гамшигаас хамгаалах менежментийн үндэс
4.	★	ENGL100	2 бц	Англи хэл-I
5.	★	ENGL 200	2 бц	Мэргэжлийн англи хэл

Зураг 23. Баталгаажсан хичээл

Хичээл баталгаажуулалт амжилттай болсон тохиолдолд баталгаажсан хичээл Зураг 23.-д үзүүлсэн шиг харагдана. Дүнгийн мэдээлэл хэсэгт хичээлийн нэр орсон байх болно



Зураг 24. Туслах мэдээлэл

Зураг 24. Хичээл бүртгүүлэх хуудасны баруун гар талд байрлах үндсэн мэдээлэл болон туслах мэдээллийн хэсгээс оюутан өөрийн кредит болон суралцах хугацааны мэдээллийг харж болно.

Нийт судалсан кредит хэсэгт оюутаны амжилттай судалсан /тэнцсэн үнэлгээ авсан/ хичээлийн кредитыг тооцсон болно.



3. Хичээлийн хуваарь

Оюутан хичээлийн хуваариараа харахдаа үндсэн хуудасны зүүн гар талд байрлах цэснээс Хичээлийн хуваарь хэсгийг сонгоно./Зураг 25./




Зураг 25. Хичээлийн хуваарь

Хичээлийн хуваарийг өдөр өдрөөр нь харах боломжтой. /Үүнд чертзтэй хичээлийг тооцсон болно./ Зураг 26.-д хичээлийн хуваарийн огноог хэрхэн сонгохыг харууллаа.



Зураг 26. Огноо сонгох


Зураг 27.-т 9 сарын 3-ны Мэдээллийн Технологийн Сургуулийн хичээлийн хуваарь харагдаж байна. Үүнээс гадна хуваарийг багшаар болон өрөөгөөр харж болно. Хуваарьт тавигдсан хичээл дээр дарж тухайн хичээлийн долоо хоногийн хуваарийг харж болно.



Зураг 27.Хичээлийн хуваарь




Хуваарьт тавигдсан хичээлээс тухайн хичээлийг заах багшийн дэлгэрэнгүй мэдээллийг харж болно. *Зураг 28.*




Зураг 28. Багшийн мэдээлэл

Хичээлийн хуваариас зөвхөн өөрийн хуваарийг харж болно. Дараах 2 аргагаар харж болно.


- ✓ Хичээлийн хуваарийн дээд хэсэгт байрлах Өөрийн хуваарь хэсгийг чагтлах *Зураг 29а.*
- ✓ Хичээл цэсний Өөрийн хичээлийн хуваарь хэсгийг сонгох *Зураг 29б.*



Зураг 29а. Өөрийн хичээлийн хуваарь



Зураг 29б. Өөрийн хичээлийн хуваарь



Зураг 30. Дүнгийн мэдээлэл

Оюутан өөрийн сонгосон байгаа болон судалсан хичээлүүдийн мэдээллийг үндсэн цэсний дүнгийн мэдээлэл хэсэгт нэвтрэн харж болно. *Зураг 30.*